



ГЭРТЭЭ БАЙЯ



ГАРАА УГААЯ



МАСКАА ЗҮҮЕ



ЗАЙГАА БАРЬЯ



MILLENNIUM
CHALLENGE CORPORATION
UNITED STATES OF AMERICA

УСНЫ САЛБАРЫН ЭРГЭН ТОЙРОНД

Долоо хоног тутмын мэдээ мэдээлэл - Монголын Мянганы сорилтын сан

№1 (7)

2020.12.27

НИЙСЛЭЛИЙГ 2021-2025 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ТАВАН ЖИЛИЙН ҮНДСЭН ЧИГЛЭЛ"-ИЙГ БАТАЛЛАА



НИТХ-ын ээлжит II хуралдаан болж, “Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл” дунд хугацааны төлөвлөлтийн баримт бичгийг хэлэлцэн баталлаа. Уг төслийг боловсруулахад нутгийн захиргааны 71 байгууллагаас 671 арга хэмжээний санал ирүүлснийг зорилго, зорилтууд давхардалгүй, уялдаатай, нэгдмэл ойлголттой, хүртээмжтэй, шалгуур үзүүлэлт нь зорилготойгоо нийцсэн, нийгмийн бүхий л давхаргад чиглэсэн байх зарчмуудыг баримтлан боловсруулжээ. Мөн “Алсын хараа 2050”, “Монгол Улсын 2021-2025 онд хөгжүүлэх үндсэн чиглэл” урт болон дунд хугацааны төлөвлөлтийн баримт бичгийн бүтцийн дагуу боловсруулсан бөгөөд дээрх хоёр баримт бичгийн “Ногоон хөгжил” бүлэг, “Үнэт баялаг ус” дэд бүлэгт усны ашиглалт, менежмент, хамгааллын талаар баримтлах бодлогын үндсэн чиглэлүүдийг тодорхой тусгасан байдаг. Мөн Нийслэлийн 2021 оны төсвийг 819 тэрбум 926 сая төгрөг байхаар батлав.

[Эх сурвалж: https://ulaanbaatar.mn/](https://ulaanbaatar.mn/)

ТҮНШЛЭЛИЙН ХӨТӨЛБӨРӨӨР УСНЫ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ БАЙГУУЛЛАГУУДЫН ЧАДАВХИЙГ САЙЖРУУЛАВ




Partnership Program Enhances Capacity of Mongolia's Water Utilities

Азийн хөгжлийн банк хэрэгжүүлсэн Усны операторуудын түншлэлийн хөтөлбөр тус байгууллагын санхүүжилтээр хаягдал ус, лагийн менежментийн чиглэлд Монголд Улсад хэрэгжүүлж буй бусад төслүүдийн үр дүнг нэмэгдүүлэхэд чухал хувь нэмэр оруулж байна. Энэхүү хөтөлбөрийн хүрээнд Өвөрхангай, Булган аймгийн усны үйлчилгээний байгууллагууд АНУ-ын Сиатл хотын Кинг каунтын цэвэрлэх байгууламжийн хэлтэстэй түншийн холбоо тогтоож ажилласан бөгөөд цэвэрлэх байгууламжийн үйл ажиллагаа, засвар үйлчилгээ, системийн хяналт удирдлага, хөрөнгө удирдлага, лагийн аюулгүй боловсруулалт ба эргүүлэн ашиглалт зэрэг олон чиглэлээр туршлага солилцуулах замаар орон нутгийн усны операторуудын чадавхийг сайжрууллаа. Түүнчлэн аюулгүй ариун цэврийн байгууламж, хаягдал ус цэвэрлэх үйл явцын талаар иргэдийн мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх замаар байгаль орчноо хамгаалах оролцоог нь нэмэгдүүлэхийг зорьсон нь энэхүү хөтөлбөрийн нэг шинэлэг тал байлаа гэж үзжээ. Эдгээр үйл ажиллагааны үр дүнд иргэд болон усны үйлчилгээний байгууллага хоорондын харилцаа, хамтын ажиллагаа сайжирсан байна.

[Эх сурвалж: https://www.adb.org/](https://www.adb.org/)

WWW.EUS.MN САЙТЫГ АШИГЛАН УСНЫ ТӨЛБӨРӨӨ ЦАХИМААР ТӨЛӨХИЙГ УРИАЛЖ БАЙНА



Дэлхий нийтийг хамраад буй Ковид-19 цар тахлын халдвар дотоодод тархаж, Монгол Улс даяар өндөржүүлсэн бэлэн байдал, хатуу хөл хорио тогтоогоод буйтай холбоотойгоор иргэд олон нийтийг онц чухал шаардлагагүй тохиолдолд гэрээсээ гарахгүй байж, цахим орчныг түлхүү ашиглахыг санал болгож байгаа билээ. Улаанбаатар хотын Ус сувгийн удирдах газраас мөн www.eus.mn хэрэглэгчийн цахим системийг ашиглан гэрээсээ гарахгүйгээр банк орохгүйгээр усны төлбөрөө төлөхийг хэрэглэгчдэдээ уриалж байна.

[Эх сурвалж: usuq.ub.gov.mn](http://usuq.ub.gov.mn)

ОЛОН УЛСЫН УСНЫ САЛБАРЫН АРГА ХЭМЖЭЭ

"УС, МЕГА ХОТУУД БА ДЭЛХИЙН ӨӨРЧЛӨЛТ" БАГА ХУРАЛД ЦАХИМААР ОРОЛЦООРОЙ



НҮБ-ын Боловсрол, шинжлэх ухаан, соёлын байгууллага буюу ЮНЕСКО-ийн Усны шинжлэх ухааны хэлтсээс санаачлан зохион байгуулдаг “Eau-Mega-2020” буюу “Ус, мега хотууд ба дэлхийн өөрчлөлт” олон улсын хоёрдугаар бага хурал дэлхий нийтийг хамраад буй Ковид-19 цар тахлын улмаар 2021 оны 12 дугаар сард зохион байгуулагдахаар хойшилсон билээ. Тэгвэл тус арга хэмжээний зохион байгуулагчид 2020 оны 12 дугаар сарын 7-ноос 11-ний өдрүүдэд “Ус, мега хотууд ба дэлхийн өөрчлөлт” сэдэвт урьдчилсан цахим хурлыг зохион байгуулж байна. Энэхүү цахим хурлаар “Усны цогц менежмент”, “Гамшгийн эрсдэлийг бууруулах нь”, “Усны үйлчилгээний тасралтгүй, тогтвортой байдлыг сайжруулах нь”, “Техник технологийн шийдлүүд” болон “Усны шинэ соёл” зэрэг олон сонирхолтой сэдвээр 30 гаруй илтгэл тавьж, хэлэлцүүлэг өрнүүлэх юм байна. Холбогдох мэдээллийг <https://en.unesco.org/events/eaumeга2021/preconference> холбоосоор авах боломжтой бөгөөд үнэ төлбөргүй оролцох боломжтой.

[Эх сурвалж: https://en.unesco.org/](https://en.unesco.org/)